

## **ТӨСӨЛ**

Санхүүгийн зохицуулах хорооны ... оны  
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар  
тогтоолын хавсралт

### **ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ БҮРТГЭХ, ХАДГАЛАХ, АРИЛЖИХ, ӨМЧЛӨХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ**

#### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэ журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооноос (цаашид “Хороо” гэх) хаалттай хувьцаат компанид хэрэгжүүлэх хяналттай холбогдсон харилцааг зохицуулж хаалттай хувьцаат компанийн хувьцааг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага (цаашид “хадгаламжийн байгууллага” гэх)-д бүртгэх, нээлттэй хувьцаат компани болох зорилгоор хаалттай хувьцаат компанийн хувьцааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага (цаашид “арилжаа эрхлэх байгууллага” гэх)-ын бүртгэлд бүртгэх, арилжихтай холбогдох харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Хадгаламжийн байгууллагын бүртгэлд бүртгүүлэх хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах нарийвчилсан журмыг хадгаламжийн байгууллага баталж, Хороогоор батламжлуулна.

1.3. Нээлттэй хувьцаат компани болох зорилгоор арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, арилжихтай холбоотой харилцааг зохицуулах нарийвчилсан журмыг арилжаа эрхлэх байгууллага баталж, Хороогоор батламжлуулна.

1.4. Энэ журмаар зөвхөн Компанийн тухай хуулийн 3.8-д заасан хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэхтэй холбоотой харилцаа, нээлттэй хувьцаат компани болох зорилгоор хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулах бөгөөд нийтэд санал болгон гаргах үнэт цаас, хаалттай хүрээнд санал болгон гаргах өрийн хэрэгслийг бүртгэх, хадгалах харилцааг зохицуулахгүй болно.

#### **ХОЁР.ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛД ХУВЬЦААГ БҮРТГЭХ**

2.1. Хадгаламжийн байгууллагын бүртгэлд хувьцаагаа бүртгүүлэхээр хүсэлт гаргаж буй хаалттай хувьцаат компани нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1. хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байх;

2.1.2. компанийн хэлбэрийг хаалттай хувьцаат компани болгох тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан байх;

## **ТӨСӨЛ**

2.1.3. татвар, шүүх болон бусад эрх бүхий байгууллагад хугацаа хэтэрсэн өргүй байх;

2.1.4. зээлийн барьцаанд үүргийн гүйцэтгэл хангуулахаар хувьцаагаа барьцаалаагүй байх;

2.1.5. хууль, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулагдах үйл ажиллагааг шударга, өөрийн болон бусад оролцогч талууд, үйлчлүүлэгчдийн эрх ашигт нийцүүлэн гүйцэтгэхийг илэрхийлсэн баталгаа гаргасан байх;

2.2. Хадгаламжийн байгууллага нь хувьцаагаа бүртгүүлэхээр хүсэлт гаргасан хаалттай хувьцаат компанийн хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хянаж, бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

2.3. Хадгаламжийн байгууллага нь хүсэлт гаргасан хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэхээс татгалзсан тохиолдолд татгалзсан үндэслэл бүхий тайлбарыг албан бичгээр ажлын 5 хоногт багтаан хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

2.4. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь хаалттай хувьцаат компанийн анх удаа болон нэмж гаргаж байгаа хувьцааг бүртгэх хүсэлтийг хүлээн авч, шаардлага хангасан гэж үзвэл эх баримт бичгийн нэг хувийг Хороонд ирүүлнэ.

2.5. Хорооны дарга энэ журмын 2.3-т заасан баримт бичигт үндэслэн зөвхөн татгалзсан тохиолдолд хариу хүргүүлэх бөгөөд тус албан бичигтээ татгалзах болсон үндэслэлээ тусгаж үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хүргүүлнэ.

### **ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛД ХУВЬЦААГ БҮРТГЭХ, АРИЛЖИХ**

3.1. Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд хувьцаагаа бүртгүүлэх хүсэлт гаргагч хаалттай хувьцаат компани нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.1.1. үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын бүртгэлд бүртгэгдсэн байх;

3.1.2. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд хувьцаагаа бүртгүүлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан байх;

3.1.3. үнэт цаасны танилцуулгатай байх;

3.1.4. хөрөнгө оруулагч тодорхойгүй бол андеррайтерийн компанитай гэрээ байгуулсан байх;

3.2. Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх хаалттай хувьцаат компанийн хувьцаа бүртгүүлэх хүсэлт болон үнэт цаасны танилцуулгад заасан хувьцааны нэр, төрөл, тоо, компанийн хувьцааны хяналтын багцыг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь эзэмшлийн хэмжээ, нэрлэсэн үнэ, хувьцааны нийт үнийн дүн

## **ТӨСӨЛ**

нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын бүртгэлийн мэдээлэлтэй ижил байна.

3.3. Андеррайтер нь хүсэлт гаргагч хаалттай хувьцаат компанийн холбогдох этгээд байж болохгүй.

3.4. Андеррайтер хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгон гаргах хувьцааг арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах ажиллагааг зохион байгуулна.

3.5. Андеррайтер нь хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгон гаргах үнэт цаасны танилцуулга болон бусад шаардагдах баримт бичгийг бэлтгэх, бүрдэлд хяналт тавих үүргийг хүлээнэ.

3.6. Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх хаалттай хувьцаат компани нь хувьцаагаа хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгон арилжаалах бөгөөд шаардлагатай тохиолдолд Хороонд бүртгэлтэй хууль, аудитын үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч, хөндлөнгийн шинжээчтэй гэрээ байгуулна.

3.7. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь нээлттэй хувьцаат компани болох зорилгоор хаалттай хувьцаат компаниар бүртгүүлэх хүсэлт гаргаж буй хаалттай хувьцаат компанийн хүсэлтийг хүлээн авч, шаардлага хангасан гэж үзвэл Хороо болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад мэдэгдэнэ.

3.8. Хорооны дарга, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага энэ журмын 3.7-д заасан мэдэгдэлд үндэслэн зөвхөн татгалзсан тохиолдолд хариу хүргүүлэх бөгөөд тус албан бичигтээ татгалзах болсон үндэслэлээ тусгаж үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хүргүүлнэ.

3.9. Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх хаалттай хувьцаат компани нь хувьцаагаа хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгон анхдагч зах зээлд амжилттай арилжаалсан тохиолдолд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгүүлж, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх хүсэлтийг Хороонд хүргүүлнэ.

3.10. Хаалттай хувьцаат компани нь андеррайтерын компанитай гэрээ байгуулсан бол энэ журмын 3.9-д заасан үүргийг андеррайтерийн компани хүлээнэ.

3.11. Арилжаа эрхлэх байгууллага нь хаалттай хувьцаат компанийн нээлттэй компани болох зорилгоор гаргасан хувьцааг мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгож, тэдгээрийн хооронд арилжаалах ба арилжаа зохион байгуулах нэгдсэн цахим системтэй байна.

3.12. Арилжаа эрхлэх байгууллага нь энэ журмын 3.11-д заасан арилжааны мэдээллийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хүргүүлнэ.

## **ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ХАСАХ**

4.1. Дараах тохиолдолд хаалттай хувьцаат компанийн хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулна. Үүнд:

## **ТӨСӨЛ**

4.1.1. хаалттай хувьцаат компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо ширхэгт өөрчлөлт оруулах шийдвэр гарсан;

4.1.2. хаалттай хувьцаат компани нь нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах болон өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдсан;

4.1.3. хаалттай хувьцаат компани нь хувьцааг хуваах, нэгтгэх, нэрлэсэн үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргасан;

4.1.4. бүртгэлтэй хувьцааны нэр өөрчлөгдсөн;

4.1.5. хууль, холбогдох журамд заасан бусад үндэслэл.

4.2. Арилжаа эрхлэх байгууллага үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын бүртгэлээс хаалттай хувьцаат компанийн хувьцааг хасах тухай шийдвэр гарсан, хаалттай хувьцаат компани нь хувьцаагаа хасуулах хүсэлт гаргасан, эсхүл хууль тогтоомжоор заасан бусад үндэслэлээр хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэлээс хасна.

4.3. Дараах тохиолдолд хаалттай хувьцаат компанийн хувьцааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжаас хасна. Үүнд:

4.3.1. компанийн хэлбэрийг өөрчлөх тухай шийдвэр гаргасан;

4.3.2. хууль, холбогдох журамд заасан бусад үндэслэл.

4.4. Хаалттай хувьцаат компани нь хувьцаагаа үнэт цаасны хадгаламжийн байгууллагын бүртгэлээс хасуулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.5. Хаалттай хувьцаат компани нь хувьцаагаа бүртгэлээс хасуулах хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад гаргана.

4.6. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь хувьцааг хадгаламжаас хасахтай холбоотой шаардлагатай гэж үзсэн нэмэлт баримт бичгийг ирүүлэхийг хадгалуулагчаас шаардаж болно.

4.7. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас хаалттай хувьцаат компанийн хувьцааг хасах тухай шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор Хороо болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хувийг хүргүүлнэ.

4.8. Хаалттай хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчийн өмнө хүлээсэн аливаа хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд арилжаа эрхлэх байгууллага болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын бүртгэлээс хасахгүй байх үндэслэл болно.

## **ТАВ. ХУВЬЦААГ ХАДГАЛАХ**

5.1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь хадгалуулж буй хувьцааг төрөл тус бүрээр нэгдсэн дугаар (код) өгч бүртгэнэ.

## **ТӨСӨЛ**

5.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь хаалттай хувьцаат компанитай хувьцааны хадгаламжийн болон түүнтэй холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ байгуулна.

5.3. Энэхүү журмын 5.2-т заасан хувьцааны хадгаламжийн гэрээнд хадгаламжийн хэлбэр, хадгалуулах хувьцааны төрөл, тоо ширхэг, хадгаламжийн үйлчилгээний хөлсний хэмжээ, хөлс төлөх хугацаа, хадгаламжийн гэрээг цуцлах нөхцөл, гэрээгээр хүлээсэн үүргийг гүйцэтгээгүйгээс үүсэх хариуцлагыг тодорхой тусгасан байна.

### **ДОЛОО. ХУВЬЦААНЫ ӨМЧЛӨХ ЭРХ БУСДАД ШИЛЖСЭНИЙГ БҮРТГЭХ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

7.1. Хувьцааны өмчлөх эрх шилжүүлэн авч байгаа этгээд өмчлөх эрх шилжүүлэн бүртгүүлэх хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт ажлын 5 хоногийн дотор үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад гаргана.

7.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь худалдах, худалдан авах гэрээний дагуу дараах баримтыг үндэслэн хувьцааны өмчлөх эрх шилжсэнийг бүртгэнэ. Үүнд:

7.2.1. худалдах, худалдан авах гэрээний эх хувь;

7.2.2. худалдах, худалдан авах гэрээний дагуу хийгдсэн төлбөр төлөгдсөн баримтын хуулбар;

7.2.3. талуудын иргэний үнэмлэхийн хуулбар.

7.3. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь хууль хяналтын болон эрх бүхий байгууллагын хүчин төгөлдөр тогтоол, шийдвэр, эсхүл үл маргах журмаар өмчлөх эрх шилжсэнийг бүртгэх тохиолдолд дараах баримтыг үндэслэнэ. Үүнд:

7.3.1. хувьцаа эзэмшигчийн хүсэлт, гэрээ дүгнэсэн акт;

7.3.2. шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудас.

7.4. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь энэхүү журамд заасан өмчлөх эрхийн гүйлгээтэй холбоотой баримтын бүрдэл, шаардлага хангасан тохиолдолд өмчлөх эрх шилжсэнийг бүртгэх бөгөөд шаардлага хангаагүй тохиолдолд өмчлөх эрх шилжүүлэн бүртгэл хийхээс татгалзах эрхтэй.

### **Бусад**

5.2. Хаалттай хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэхэд Хорооноос тогтоосон хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг баримтлах бөгөөд харин 50 буюу түүнээс доош тооны хувьцаа эзэмшигчтэй бол тус журмыг мөрдөхгүй байж болно. Энэ тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх арга, журмыг компанийн дүрэмд заавал тусгана.

## ТӨСӨЛ

5.4. Хаалттай хувьцаат компани нь ногдол ашиг хуваарилахдаа Хорооноос тогтоосон хувьцаат компанийн ногдол ашиг тараалтад хяналт тавих журмыг баримтлах бөгөөд харин 50 буюу түүнээс доош тооны хувьцаа эзэмшигчтэй бол тус журмыг мөрдөхгүй байж болно.

~oOo~